



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 1/60

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын Чао Яанг эмнэлэг хооронд 2017 оны 12 дугаар сарын 06-ны байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын  
 2020 оны 01 сарын 24-ны өдрийн  
 А. дугаар тушаалын хавсралт  


МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хан Шю Ву Han Xiuwu	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын Чао Янг эмнэлэг	ГЭ00002506	Бөөрний мэс засал судлал	Эмчлэх	2020.01.20-2020.01.24 /5 хоног/